



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/111


Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2015 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”, Архангай аймгийн Эрүүл мэндийн газар, Канад Улсын Лаурел сан хооронд 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 03 сарын 02-ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хью Макферсон Парсонс Hugh Macpherson Parsons	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	Канад Улсын Лаурел сан	ГЭ0002211	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2019.03.12-2019.04.25 /1 сар 14 хоног/
2.	Франсис Чи Хунг Ло Fransis Chi Hung Law	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	Канад Улсын Лаурел сан	ГЭ0002212	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2019.03.12-2019.04.25 /1 сар 14 хоног/